

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар № 07

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1,1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. "Амгалан дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг "Амгалан дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ




ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ

ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯРЗЭРДЭНЭ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2023 оны 05 дугаар сарын 02-ны
өдрийн 07 дугаар тогтоолын хавсралт



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ДҮРЭМД ОРОХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

- 1.1 Компанийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт “...100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд” гэснийг “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компани 100 хувь төрийн өмчит хаалттай хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 66 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34 хувийн төлөөллийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх;
- 1.2 Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,099,343,672 ширхэг энгийн хувьцаа байна” гэснийг “...нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 995,989,873 (Есөн зуун ерэн таван сая есөн зуун наян есөн мянга найман зуун далан гурав)-н ширхэг энгийн хувьцаа байна.” гэж;
- 1.3 Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.20 дахь заалтаар “Компанийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын жагсаалтыг батална.” гэх
- 1.4 Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт “....тэргүүн дэд захирал бөгөөд, дэд захирал...” гэснийг “Гүйцэтгэх захирал нь Ерөнхий инженер, Ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө...” гэж
- 1.5 Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалтыг “...эрчим хүчний инженер, эсхүл эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх” гэснийг “Менежментийн ур чадвартай, 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, удирдлагын зохих дадлага туршлагатай, эрчим хүчний инженер /0713 цахилгаан, эрчим хүч/, эсхүл /усан хангамж, сантехникийн инженерчлэл 073201, 073202/ менежмент ба удирдахуй /0413/ чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх” гэж
- 1.6 Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.3 дахь заалтыг “Ял шийтгэлгүй байх” гэснийг “Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй” гэж нэхэм;
- 1.7 Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9.13 дахь заалтаар “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, батлуулна.” гэх,

1.8 Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “...Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Дэд захирал, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, цех, хэлтэс, албаны дарга нарыг...” гэснийг “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Дотоод аудитор, Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, Ерөнхий нягтлан бодогч, цех, хэлтсийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.” гэж

1.9 Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэгт “ Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод аудитор хэрэгжүүлнэ.” гэснийг “Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон дотоод аудитор хэрэгжүүлнэ.” Гэж

1.10 Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.10 дахь хэсэгт “ Дотоод хянан шалгагч нь” гэснийг “Дотоод аудитор нь” гэж

1.11 Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.11 дэх хэсэгт “Дотоод хянан шалгагч нь.....” гэснийг “Дотоод аудитор нь” гэж